

**Аудитын код: САГ-2018/85/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Д.Цэгмиддорж  
Утас: 261740 Цахим хаяг: [tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

**Гүйцэтгэгч:**

**Ол дөш хайрхан-аудит ХХК**

Захирал: А.Саранцэцэг

Утас: 99250679

И-мэйл: [saraa\\_1303@yahoo.com](mailto:saraa_1303@yahoo.com)

Ахлах аудитор: Т.Сарантуяа

Утас: 99194484

И-мэйл: [saraa\\_tu@yahoo.com](mailto:saraa_tu@yahoo.com)

Хаяг: Хан-Уул дүүрэг,

3 дугаар хороо, ЭХБУТ компанийн байр 2 давхар давхар 206 тоот

Улаанбаатар хот



## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	1
2.1	Оршил .....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	1
2.3	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН .....	1
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН .....	2
2.5	Дотоод хяналт .....	2
2.6	Компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	4
2.9.1	Авлага дансны талаар.....	4
2.9.2	Богино хугацаат өр төлбөрийн талаар.....	4
2.9.3	Богино хугацаат зээлийн тооцооны талаар .....	4
2.9.4	Урт хугацаат өр төлбөр .....	5
2.9.5	Бараа материал дансны талаар.....	5
2.9.6	Үндсэн хөрөнгийн талаар.....	6
2.9.7	Зардлын дансны талаар .....	6
2.9.8	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаар .....	6
2.9.9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар .....	7
2.10	АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ .....	7
2.11	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД .....	7
2.12	АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	7
2.13	ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	7
2.14	МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:.....	7
2.15	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ .....	8
3	Үйлчлүүлэгчийн хариу .....	9
4	Менежментийн захидал .....	10
4.1	АВЛАГА ДАНСНЫ ТАЛААР.....	11
4.2	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР .....	12
4.3	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛИЙН ТООЦООНЫ ТАЛААР .....	12
4.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	13
4.5	БАРАА МАТЕРИАЛЫН ДАНСНЫ ТАЛААР .....	14
4.6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР .....	15
4.7	ЗАРДАЛ ДАНСНЫ ТАЛААР .....	16
4.8	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаар.....	18
4.9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	18
5	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	19
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	20
5.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	20
5.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	23



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/676  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Д.ГАНБОЛД  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монголпросцветмет” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Монголпросцветмет” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монголпросцветмет” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kherreg\Yawsan\_Bichig\2018\0315SAG1.Docx

070958

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Аудитын гол асуудал

“Монголросцветмет” ХХК-ийн статус нь тодорхойгүй, 2017 оны жилийн эцсийн тооллогоор 4.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө, 36.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө дутсан бөгөөд эзэн холбогдогч нь олдохгүй байгаа шалтгаанаар 2008 оноос хойш өнөөг хүртэл асуудлыг шийдвэрлээгүй, хөрөнгийн дансанд бэлэн байгаагаар бүртгэсэн, 348.2 сая төгрөгийн авлага, 405.9 сая төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг нийт 835.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн байна.


Эдгээр зөрчил нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүйн зэрэгцээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтууд, СТОУС 13-т нийцэхгүй байна.

### Үүрэг, хариуцлага

“Монголросцветмет” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ





## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг тус компанийн ерөнхий захиралд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчил, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2017 онд Монголросцветмет ХХК-ийн статус нь тодорхойгүйгээс санхүүгийн тайланд аудит хийхэд хүндрэлтэй байлаа.

Менежментийн захидалд: Авлага үүсгэхгүй байх, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, богино хугацаат зээлийн өглөгийг төлж барагдуулах, үргүй зардлыг бууруулах, тооллогоор илэрсэн үр дүнг холбогдох хууль журамд нийцүүлэн шийдвэрлэх, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой гарч буй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх гэсэн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан, аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явууллаа.

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монголросцветмет ХХК нь Санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

01

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-нөөс 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, Ол дөш хайрхан аудит ХХК-ийн аудитор А. Саранцэцэг, Т. Сарантуяа, Ц. Бумцэнд, Ц.Саранцэцэг, аудиторын туслах С.Хажид, О.Эрдэнэбат нар хэрэгжүүлж ажиллав.

### **2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Монголросцветмет ХХК нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, өмнөө тавьсан зорилгод хүрэх зарчмыг баримталж, өрсөлдөх чадварынхаа давуу талыг дээд зэргээр ашиглахад үйл ажиллагаагаа чиглүүлэх зорилготой ажиллаж байна.

Монголросцветмет ХХК-ийн бүрэлдэхүүнд Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр (УБҮ), Зэрэгцээ алтны уурхай, Асгатын мөнгөний орд газар, Баргилтын төмрийн хүдрийн цех багтдаг ба ОХУ-ын Москва хот болон БНХАУ-ын Эрээн хотод төлөөлөгчийн газар, Улаанбаатар хот, Бор-Өндөрийн УБҮ-т орон сууц, нийтийн аж ахуйн объектууд ажиллаж байна.

Монголросцветмет ХХК нь Хэнтий, Төв аймгийн нутаг дэвсгэрт хайлуур жоншны баяжмалыг ил болон далд уурхайгаас үйлдвэрлэх, төмрийн хүдэр ил уурхайгаас олборлож, баяжмал боловсруулах, алт, мөнгө олборлох, шинэ ордуудын геологичайгуулын ажил хийх зэрэг үндсэн үйл ажиллагааг эрхлэхээс гадна орон сууцны түрээс, цэцэрлэг, сургууль, зочид буудал, зоогийн газар ажиллуулах, дулаан болон цахилгаан, усны төлбөрийг төвлөрүүлэх зэрэг туслах үйл ажиллагааг орон нутгийн удирдлагатай хамтран явуулж байна.

Монголросцветмет ХХК нь хямралын эсрэг авч буй арга хэмжээний талаарх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хайлуур жоншны хэрэглээний шинэ зах зээлийг судалж, томоохон хөрөнгө оруулагчдаас хөрөнгийн эх үүсвэр татах, хамтран ажиллахад анхаарч байна.

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Бор-Өндөрийн УБҮ, Зэрэгцээ алтны уурхай, Москва, Эрээний төлөөлөгчийн газар, төв компанийн тайлан нэгтгэгдсэн байна.

Монголросцветмет ХХК нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2017 оны үйлдвэрлэл санхүүгийн бизнес төлөвлөгөөг батлуулахаар 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/1388 тоотоор хүргүүлсэн ч хариу ирээгүй байна.

Монголросцветмет ХХК-ийн хувь эзэмшил Монгол Улсын хуулийн этгээдэд бүрэн шилжсэн ч компанийн статусын асуудал шийдвэрлэгдээгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг сонгож, батлах боломж бүрдээгүй зэргээс бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх удирдлага нь баталсан байна

Монголросцветмет ХХК-ийн Зөвлөлийн 2017 оны 46 дугаар байгууллага хуралдаанаар тус компанийн 100 хувь охин компани болох "Шижир-Алт" ХХК-ийг тусгай буулгахаар шийдвэрлэсэн боловч татан буулгах ажил 2017 оны 4 дугаар сар хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Гэтэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А-1/713 дугаар албан тоотоор Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх зорилгоор “Алт-2” үндэсний хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу “Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах үйл ажиллагааг хуулийн дагуу зогсоож, алт олборлох, баяжуулах үндсэн үйл ажиллагааг дахин сэргээн ажиллаж эхэлсэн байна.

Монголросцветмет ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Компанийн тухай, Ашигт малтмалын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Маягт, заавар батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/


Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 28 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцож 724.4 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Даймонд” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **2.5 Дотоод хяналт**

Монголросцветмет ХХК-ийн дотоод хяналт мониторингийн мэргэжилтэн нь Ерөнхий захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн хамт удирдамжийн дагуу Бор Өндөрийн УБҮ, Зэрэгцээ, Шижир-Алт ХХК-ийн алтны уурхайн тайлант жилийн үйлдвэрлэл, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд 5 удаагийн дотоод хяналт



шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг компанийн Ерөнхий удирдлагад танилцуулж, харьяа үйлдвэр, хэлтэс, албан тушаалтнуудад хүргүүлэн ажилласан байна. Гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар Бор-Өндөр УБҮ-т 72 зүйлийн зөвлөмж, Зэрэгцээ алтны уурхайд 19 зүйлийн зөвлөмж, Шижир-Алт ХХК-д 9 зүйлийн зөвлөмж өгч, гүйцэтгэлд нь төв компанийн захиргааны хэлтэстэй хамтран хяналтын програм ашиглан хяналт тавьж ажилласнаар ихэнх зөвлөмжүүд нь хэрэгжсэн байна.

2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс компанийн хэмжээнд дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даан зохион байгуулах, гүйцэтгэх үүрэг бүхий дотоод хяналтын хэлтэс 3 орон тоотойгоор байгуулагдсан. Ерөнхий захирлын 2018 оны А/08 тоот тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг шинэчлэн баталсан байна.

## 2.6 КОМПАНИЙН ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монголросцветмет ХХК нь 2017 онд 1317 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж, 21.9 мянган тонн хайлуур жоншны баяжмал, 314.2 мянган тонн төмрийн баяжмалын бүтээгдэхүүн, 1,030.1 мянган тонн төмрийн хүдэр, 34.8 кг алт борлуулж, 82,883.8 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас 82,883.8 сая төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 5,269.9 сая төгрөг, нийт 88,153.7 сая төгрөгийн орлоготой ажилласан, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 41,927.7 сая төгрөг, санхүүгийн зардалд 2,355.1 сая төгрөг, ерөнхий удирдлагын ба борлуулалтын зардалд 13,854.7 сая төгрөг, үйл ажиллагааны бусад зардалд 8,651.5 сая төгрөг, нийт 66,789.0 сая төгрөгийн зардал гаргаж, орлогын татварын зардалд 5,651.6 сая төгрөгийг тооцож, жилийн эцэст 15,713.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Хэдийгээр үндсэн үйл ажиллагаанаасаа ашигтай ажилласан боловч үндсэн бус үйл ажиллагаанаасаа 4,489.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны алдагдалд материаллаг урамшуулалын санд 158.8 сая төгрөг, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх санд 404.4 сая төгрөг, үйлдвэрлэл хөгжүүлэх санд 61.6 сая төгрөг, үйлдвэрлэлийн сул зогсолтын зардалд 3,616.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь нөлөөлжээ.


2017 онд нийт үйлдвэрлэл болон үйл ажиллагааны зардлын төсөв 71,902.9 сая төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 67,844.4 сая төгрөгийн зардалтай ажилласнаар зардлыг 4,076.5 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар бууруулсан байна. Гэвч цахилгаан эрчим хүчний зардал, элэгдэл хорогдлын зардал, сэлбэг материалын зардал 45.5-435.6 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

“Монголросцветмет” ХХК өөрийн <http://www.mongolros.mn/> нэртэй цахим хуудасны “шилэн данс” цэсэнд хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаарх мэдээллийг байршуулж, бусад гэсэн хэсэгт мэдээлэл оруулаагүй байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 36 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 28 нарийвчилсан гэржээг гүйцэтгэв.





## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Авлага дансны талаар

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3,055.4 сая төгрөгийн дансны авлага, 930.6 сая төгрөгийн татвар, НДШ-ийн авлага тусгагдсанаас 91.3 хувь буюу 3,639.2 сая төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулсан, харин 8.7 хувь буюу 348.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна.

Нийт авлагын насжилтыг авч үзвэл: 2015 он болон түүнээс өмнө үүссэн авлага нийт авлагын 13.5 хувь, 2016- 2017 онд үүссэн авлага 86.5 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр авлагаас 106.2 сая төгрөгийн авлага нь 2012 он болон түүнээс өмнө үүссэн, барагдуулах найдваргүй авлага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлагыг барагдуулахад анхаарах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20.2.6. дахь заалтуудыг хэрэгжүүлж, ажиллах зөвлөмж өгөх.

### 2.9.2 Богино хугацаат өр төлбөрийн талаар


Санхүүгийн тайлангаар дансны 6,075.1 сая, цалингийн 1,029.4 сая, татварын 6,909.4 сая, НДШ-ийн 4,895.7 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна. Энэхүү өр төлбөрөөс 93.3 хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан, 6.7 хувь буюу 405.9 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгийг зохистой удирдах, өр төлбөр, авлага үүсгэхгүй байх хуулийн заалтад нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, өглөгийг барагдуулахад анхаарч ажиллах Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

### 2.9.3 Богино хугацаат зээлийн тооцооны талаар

2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Голомт банкнаас жилийн 15 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай 4.0 сая ам. долларын зээл авсан боловч зээлээ тэрээнд заасан хугацаанд төлөөгүй учраас Голомт банк шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.



Энэ дагуу хоёр талын итгэмжилсэн төлөөлөгч нар 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр эвлэрлийн гэрээ байгуулж, оны эцэст 3.6 сая ам. долларын үлдэгдэлтэй гэж тооцон санхүүгийн тайландаа тусгасан байна. Авсан зээлээ хугацаанд нь төлөөгүйн улмаас үргүй зардал гарах эрсдэл үүсч байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зээлээ төлж барагдуулах зөвлөмж өгөх.

#### 2.9.4 Урт хугацаат өр төлбөр

2007 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдсан “Монголросцветмет” ХХК-ийн Зөвлөлийн 37 дугаар хурлын шийдвэрийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай MR-2007-07-72 тоот хамтран ажиллах гэрээ байгуулан “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах фабрикийн шинэчлэлтэнд зориулж 5.5 сая ам. долларын зээл авсан боловч төлөлт огт хийгдэхгүй байснаас 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт гэрээгээр энэхүү зээлийн эргэн төлөх хуваарийг 2015 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэсэгчлэн төлж барагдуулахаар өөрчилсөн байна. Гэвч нэмэлт гэрээ мөн адил хэрэгжээгүй байна.


**Шийдвэрлэсэн нь:** Урт хугацаат зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгөх.

#### 2.9.5 Бараа материал дансны талаар

- 2017 оны жилийн эцсийн тооллогоор эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 36.8 сая төгрөгийн хөрөнгө дутсан;
- Дутагдсан хөрөнгийг хариуцсан эзэн холбогдогч нь тодорхойгүй шалтгаанаар төлүүлэхгүй олон жил асуудлыг шийдвэрлээгүй, данс бүртгэлд тусгасан хэвээр байна.
- Зэрэгцээ алтны үйлдвэр, Захиргаанд нийт 6.3 сая төгрөгийн цаашид огт ашиглахгүй бараа материал, сэлбэг хэрэгсэл бараа материалын дансанд бүртгэлтэй байна.
- Монголросцветмет ХХК, Зэрэгцээ алтны уурхайн захирлууд нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх, тооллогын комисс томилох тухай тушаал гаргахдаа тооллогын комисст ахлах нягтлан бодогч, салбарын ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, кассын нярав нарыг томилсон. Мөн Зэрэгцээ алтны үйлдвэрийн материалын нягтлан бодогч нь кассын няравын ажлыг хийж байна.

Эдгээр зөрчлүүд нь: Санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан заалтыг, СТОУС 13-н дагуу аливаа хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20.2.11 “өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлыг гүйцэтгэлийг хянах, ...” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.



**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 20.2.6 дахь заалтууд, тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулах, компанийн хуульчтай хамтран хууль хяналтын байгууллагад шилжүүлж, хохирлыг барагдуулах, СТОУС 13-ийн дагуу шийдвэрлүүлэх, тооллогын комисст нягтлан бодогч нарыг оруулдаг явдлыг зогсоох зөвлөмж өгөх.

## 2.9.6 Үндсэн хөрөнгийн талаар

2017 оны жилийн эцсийн тооллогоор 1994-2008 оны хооронд ашиглалтанд орсон Монголросцветмет ХХК-ийн харьяанд байдаг Орон сууц, нийтийн аж ахуйн газарт бүртгэлтэй байсан 23.1 сая төгрөгийн анхны үнэтэй, 4.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө дутагдсан байхад одоо болтол данс бүртгэлд тусгасан хэвээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан заалтыг зөрчсөн, Санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна

**Шийдвэрлэсэн нь:** Тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулах, компанийн хуульчтай хамтран хууль хяналтын байгууллагад шилжүүлж, хохирлыг барагдуулах, санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

## 2.9.7 Зардлын дансны талаар

Орон сууц, нийгэм соёлын зориулалттай байгууламжийг тухайн орон нутагт нь шилжүүлэх ажил хийгдээгүйгээс ашиглалтын зардалд 238.5 сая төгрөг зарцуулсан нь УИХ-ын 29 дүгээр тогтоол, Ерөнхий захирлын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн №67 тоот хэмнэлтийн горимд шилжих тухай тушаалтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** УИХ-ын 29 дүгээр тогтоол, Ерөнхий захирлын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн №67 тоот хэмнэлтийн горимд шилжих тухай тушаалыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх.


## 2.9.8 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаар

Тус компанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө 112.7 хувиар, борлуулалт 103.8 хувиар биелсэн байна.

Төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: алт олборлолт, металлургийн баяжмал ФК-75 зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт тасарсан байна.

Монголросцветмет ХХК нь 2017 онд бүтээгдэхүүн борлуулалтын гадаад зах зээлийн гэрээг Хойд Хятадын CFR үнийг жишиг суурь болгож, DAP Эрээн нөхцөлөөр байгуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гадаад зах зээлийн үнэ болон боломжит хувилбаруудыг судлах, бизнес төлөвлөгөөг зах зээлийн үнэтэй уялдуулан боловсруулах, төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх зөвлөмж өгөх.



## 2.9.9 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Монголросцветмет ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “...Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасан заалтыг хэрэгжүүлэн НБББББ-ийг батлуулан, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

## 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол Улсын Их хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолд Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн Монголросцветмет ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлыг яаралтай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Монголросцветмет ХХК-ийн статусын асуудал өнөөдрийг хүртэл бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа нь гол анхаарал татахуйц чухал асуудал болж байна.

## 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Монголросцветмет ХХК-ийн экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг Сангийн Яамнаас нийтэд мэдээлсэн уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн мэдээлэлтэй харьцуулж дүгнэлт гаргах болон эд хөрөнгийн тооллогын явцыг ажиглах горим, сорилыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гүйцэтгэж чадаагүй тул дараагийн аудитаар авч үзэх болно

## 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 835.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 835.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өглөө.

## 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 оны аудитын тайлангаар өгсөн 10 зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхий захирлын 2017 оны №1/917 дугаар тушаал гарч, арга хэмжээ авч ажилласны үр дүнд 8 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

## 2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг суурийг тайлангийн нийт зардлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын



1 хувиар тооцож 724.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монголросцветмет ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан: Монголросцветмет ХХК-ийн статус нь тодорхойгүй, 2017 оны жилийн эцсийн тооллогоор 4.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө, 36.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө дутсан бөгөөд эзэн холбогдогч нь олдохгүй байгаа шалтгаанаар 2008 оноос хойш одоо болтол асуудлыг шийдвэрлээгүй хөрөнгийн дансанд бэлэн байгаагаар бүртгэсэн, 348.2 сая төгрөгийн авлага, 405.9 сая төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, нийт 835.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тооцсон материаллаг түвшнөөс хэтэрсэн байна.

Эдгээр зөрчил нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаагийн зэрэгцээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтууд, СТОУС 13-т нийцэхгүй байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгөх саналтай байна.

## АУДИТЫН ТАЙЛАНГ

### Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Ц. Саранцэцэг

Ц. Бумцэнд

Аудиторын туслах

С. Хажид

О. Эрдэнэбат

### Хянасан:

Захирал /аудитор/

А. Саранцэцэг

Чанарын хяналт хариуцсан аудитор

Т. Сарантуяа



3 Үйлчлүүлэгчийн хариу

  
**МОНГОЛРОСЦВЕТМЕТ**  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ  
13341 Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98,  
Утас: 45-80-72, Факс: (976-11) 45-83-80, 45-84-30,  
E-mail: mailbox@monros.mn; http://www.mongolros.mn  
2018.03.12, № 1/309  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ОЛДӨШ ХАЙРХАН АУДИТ” ХХК-д

Менежментийн захидлаар өгөгдсөн тэргүүлэх ач холбогдол бүхий зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ЕРӨНХИЙ ЗАХИГААГЧ  Д.ГАНБОЛД  
ЕРӨНХИЙ НЯТГАА ВЕЛОГЧ  Д.БАЯРБАТ



0036

#### 4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монголросцветмет ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**4.1 Авлага дансны талаар****Тэргүүлэх ач холбогдол №1****Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

Монголросцветмет ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3,055.4 сая төгрөгийн дансны авлага, 930.6 сая төгрөгийн татвар, НДШ-ийн авлага тусгагдсанаас 91.3 хувь буюу 3,639.2 сая төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулсан, харин 8.7 хувь буюу 348.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна.

Нийт авлагын насжилтыг авч үзвэл: 2015 он болон түүнээс өмнө үүссэн авлага нийт авлагын 13.5 хувь, 2016- 2017 онд үүссэн авлага 86.5 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр авлагаас 106.2 сая төгрөгийн авлага нь 2012 он болон түүнээс өмнө үүссэн, барагдуулах найдваргүй авлага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20.2.6. “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Авлага, өр төлбөр үүссэн байх, тооцоо хийхгүй байх, үлдэгдлийг баталгаажуулаагүй байх, дансны бичилт буруу хийсэн, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах,

**Ол дөш хайрхан аудит ХХК -ний зөвлөмж**

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлага барагдуулахад анхаарч ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20.2.6. дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.





<b>4.2 Богино хугацаат өр төлбөр</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
--------------------------------------	----------------------------------

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

Санхүүгийн тайлангаар дансны 6,075.1 сая, цалингийн 1,029.4 сая, татварын 6,909.4 сая, НДШ-ийн 4,895.7 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна. Энэхүү өр төлбөрөөс 93.3 хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан, 6.7 хувь буюу 405.9 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгийг зохистой удирдах, өр төлбөр, авлага үүсгэхгүй байх хуулийн заалтад нийцээгүй байна.

**Эрсдэлүүд**

Богино хугацаат өр төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулаагүйгээс алдагдал хүлээж компанийн эдийн засгийн үр ашгийг бууруулсан байх,

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, өглөгийг барагдуулахад анхаарч ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

<b>4.3 Богино хугацаат зээлийн тооцооны талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
--	----------------------------------

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**


2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Голомт банкнаас жилийн 15 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай 4.0 сая ам. долларын зээл авсан боловч зээлээ гэрээнд заасан хугацаанд төлөөгүй учраас Голомт банк шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Энэ дагуу хоёр талын итгэмжилсэн төлөөлөгч нар 2017 оны 12 дугаар сарын 18 -ны өдөр эвлэрлийн гэрээ байгуулж, оны эцэст 3.6 сая ам. долларын үлдэгдэлтэй гэж тооцон санхүүгийн тайландаа тусгасан байна. Авсан зээлээ хугацаанд нь төлөөгүйн улмаас үргүй зардал гарах эрсдэл үүсч байна.

**Эрсдэлүүд**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

Зээлээ төлж барагдуулах зөвлөмж өгөх.



Зээлийг цаг хугацаанд төлөөгүйгээс компани хүү алданги, торгуульд орсон байх,

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

<b>4.4 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
-----------------------------------	----------------------------------

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

2007 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдсан “Монголросцветмет” ХХК-ийн Зөвлөлийн 37 дугаар хурлын шийдвэрийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай MR-2007-07-72 тоот хамтран ажиллах гэрээ байгуулан “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах фабрикийн шинэчлэлтэнд зориулж 5,505 мянган ам.долларын зээл авсан боловч төлөлт огт хийгдэхгүй байснаас 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт гэрээгээр энэхүү зээлийн эргэн төлөх хуваарийг 2015 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэсэгчлэн төлж барагдуулахаар өөрчилсөн байна. Гэвч нэмэлт гэрээ мөн адил хэрэгжээгүй байна.

**Эрсдэлүүд**

Урт хугацаат өр төлбөр цаг хугацаанд нь барагдуулагүйгээс алдагдал хүлээж компанийн эдийн засгийн үр ашгийг бүүрсан байх

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

Урт хугацаат зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.



4.5 БАРАА МАТЕРИАЛЫН ДАНСНЫ ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №2
<p><b><u>Ол дөш хайрхан аудит ХХК-ны ажиглалт</u></b></p> <p>2017 оны жилийн эцсийн тооллогоор эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 36.8 сая төгрөгийн хөрөнгө дутсан байна.</p> <p>Дутагдсан хөрөнгийг хариуцсан эзэн холбогдогч нь тодорхойгүй шалтгаанаар төлүүлэхгүй олон жил асуудлыг шийдвэрлээгүй, данс бүртгэлд тусгасан хэвээр байна.</p> <p>Зэрэгцээ алтны үйлдвэр, Захиргаанд нийт 6.3 сая төгрөгийн цаашид огт ашиглахгүй бараа материал, сэлбэг хэрэгсэл бараа материалын дансанд бүртгэлтэй байна.</p> <p>Монголросцветмет ХХК, Зэрэгцээ алтны уурхайн захирлууд нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх, тооллогын комисс томилох тухай тушаал гаргахдаа тооллогын комисст ахлах нягтлан бодогч, салбарын ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, кассын нярав нарыг томилсон. Мөн Зэрэгцээ алтны үйлдвэрийн материалын нягтлан бодогч кассын няравын ажлыг хийж байна.</p> <p>Эдгээр зөрчлүүд нь: Санхүүгийн тайлангийн Бодитой оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан заалтыг, СТОУС 13-н дагуу аливаа хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх гэсэн шаардлагыг хангахгүй байна.</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20.2.11 “өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, ...” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.</p> <p><b><u>Эрсдэлүүд</u></b></p> <p>Бараа материалын тооллогоор үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, бүртгэлээрх үлдэгдлээс илүү, дутуу гарах, хөрөнгийн ангилалыг буруу бүртгэсэн байх, эргэлтийн хөрөнгийг шамшигдуулах,</p>	<p><b><u>Ол дөш хайрхан аудит ХХК-ний Зөвлөмж</u></b></p> <p>Тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулах, компанийн хуульчтай хамтран хууль хяналтын байгууллагад шилжүүлж, хохирлыг барагдуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэх, СТОУС 13-ийн дагуу шийдвэрлүүлэх, тооллогын комисст нягтлан бодогч нарыг оруулдаг явдлыг зогсоох зөвлөмж өгөх.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p> <p><b><u>Үйлчлүүлэгчийн хариу</u></b></p> <p>Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.</p> <div data-bbox="991 1928 1519 2085" style="border: 1px solid black; padding: 5px; display: flex; align-items: center;"> <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-right: 10px; font-size: 24px; font-weight: bold;">01</div> <div style="border: 1px solid black; padding: 5px;"> <p style="font-size: 10px; margin: 0;">ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА</p> <p style="font-size: 12px; margin: 0; font-weight: bold;">ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ</p> </div> </div>

**4.6 Үндсэн хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

2017 оны жилийн эцсийн тооллогоор 1994-2008 оны хооронд ашиглалтанд орсон Монголросцветмет ХХК-ийн харьяанд багтдаг Орон сууц, нийтийн аж ахуйн газарт бүртгэлтэй байсан 23.1 сая төгрөгийн анхны үнэтэй, 4.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө дутагдсан байхад одоо болтол данс бүртгэлд тусгасан хэвээр байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан заалтыг зөрчсөн байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн Бодитой оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгээгүй байх, ашиглал шамшигдал үүсэх, бэлтгэх, бүртгэх, данс бүртгэлээс хасах үйл ажиллагаа нь холбогдох хууль, заавар журамд нийцээгүй байх,

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

Тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулах, компанийн хуульчтай хамтран хууль хяналтын байгууллагад шилжүүлж, хохирлыг барагдуулах, санхүүгийн тайлангийн Бодитой оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг хэрэгжүүлж, ажиллах талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.





**4.7 ЗАРДАЛ ДАНСНЫ ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

Орон сууц, нийгэм соёлын зориулалттай байгууламжийг тухайн орон нутагт нь шилжүүлэх ажил хийгдээгүйгээс ашиглалтын зардалд 238.5 сая төгрөг зарцуулсан нь УИХ-ын 29 дүгээр тогтоол, Ерөнхий захирлын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн №67 тоот хэмнэлтийн горимд шилжих тухай тушаалтай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

төлөвлөөгүй зардал гаргасан байх, тайлант оны баталсан зардлын төсөв болон норматив, лимиттэй зардлыг гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлдэггүй байх, Цалингаас тооцож буй НДШ,ХХОАТ-ыг буруу тооцож бүртгэсэн байх, СТОУС 6 буюу Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээний 6.20 дугаар заалт, Сангийн сайдын 2011 онд баталсан Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журмын хэрэгжилтийг хангаагүй байх,

УИХ-ын 29 дүгээр тогтоол, Ерөнхий захирлын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн №67 тоот хэмнэлтийн горимд шилжих тухай тушаалыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

**4.8 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

Тус компанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө 112.7 хувиар, борлуулалт 103.8 хувиар биелсэн байна.

Төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: алт олборлолт, металургийн баяжмал ФК-75 зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт тасарсан байна.

Монголросцветмет ХХК нь 2017 онд бүтээгдэхүүн борлуулалтын гадаад зах зээлийн гэрээг Хойд Хятадын CFR үнийг жишиг суурь болгож, DAP Эрээн

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

Гадаад зах зээл болон боломжит хувилбаруудыг судлах, бизнес төлөвлөгөөг зах зээлийн үнэтэй уялдуулан боловсруулах, төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх зөвлөмж өгөх.



нөхцөлөөр байгуулсан байна. Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг Сангийн Яамнаас нийтэд мэдээлсэн уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн мэдээлэлтэй харьцуулсан дүгнэлтийг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад нарийвчилан мөшгиж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх болно.

**Эрсдэлүүд**

Үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг биелүүлээгүй байх, зардлыг хэмнэх, чанарт байнга анхаарч, дотоод хяналт сайнгүй байх;

Гадаад, дотоодын зах зээл дээр бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулахад анхаараагүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Менежментийн захидлаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

<b>4.9 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
--	----------------------------------

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний зөвлөмж**

**Ол дөш хайрхан аудит ХХК-ний ажиглалт**

Монголросцветмет ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “...Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батална” гэж заасныг зөрчсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасан заалтыг хэрэгжүүлэн НБББББ-ийг батлуулан, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;



## 5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 5.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
	2017 оны 01 сарын 01	2017 оны 12 сарын 31
Б	1	2
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b><u>26,751,855,510.42</u></b>	<b><u>29,872,883,242.48</u></b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	927,865,281.38	2,140,628,114.41
Дансны авлага	3,076,011,500.21	3,055,437,852.01
Татвар, НДШ-ийн авлага	1,548,529,044.82	930,650,090.27
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	15,870,018,571.21	19,293,716,599.06
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,329,431,112.80	4,452,450,586.73
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b><u>26,751,855,510.42</u></b>	<b><u>29,872,883,242.48</u></b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	26,483,536,542.03	26,357,986,042.54
Биет бус хөрөнгө	1,601,340,418.71	1,979,869,627.22
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,158,820,000.00	2,158,820,000.00
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,744,442,236.98	2,746,411,872.98
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,246,493,038.76	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Дуусаагүй барилга	1,591,219,552.89	1,445,635,002.83
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b><u>36,825,851,789.37</u></b>	<b><u>34,688,722,545.57</u></b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>63,577,707,299.79</u></b>	<b><u>64,561,605,788.05</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>		
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	10,957,645,735.18	6,075,065,085.49
Цалингийн өглөг	1,249,842,745.02	1,029,378,868.05
Татварын өр	8,783,366,662.85	8,909,459,065.04
НДШ-ийн өглөг	5,680,797,733.51	4,895,732,693.15
Богино хугацаат зээл	22,070,430,055.34	8,699,570,079.57

Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	5,769,014,085.49	11,071,483,264.50
Нөөц / өр төлбөр /	1,300,026,712.08	1,674,583,594.59
Бусад богино хугацаат өр төлбөр	14,444,358,578.96	14,883,201,550.61
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр	-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>70,255,482,308.43</u></b>	<b><u>55,138,475,071.00</u></b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц / өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	205,921,754.71
Бусад урт хугацаат өр төлбөр	13,704,862,650.00	13,361,350,650.00
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>13,704,862,650.00</u></b>	<b><u>13,567,272,404.71</u></b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b><u>83,960,344,958.43</u></b>	<b><u>68,705,747,475.71</u></b>
<b>2. Эзэмшигчдийн өмч</b>		
Өмч : а) төрийн	625,661,880.00	625,661,880.00
б) хувийн	601,126,120.00	601,126,120.00
Халаасны хувьцаа	-	-
<b>Хувьцаат капиталын дүн</b>	<b><u>1,226,788,000.00</u></b>	<b><u>1,226,788,000.00</u></b>
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Дахин үнэлгээний нөөц	12,265,209,146.83	12,265,209,146.83
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(33,874,634,805.47)	(17,636,138,834.49)
Тайлангийн үеийн	(14,457,741,714.14)	15,713,176,281.08
Өмнөх үеийн	(19,416,893,091.33)	(33,349,315,115.57)
		)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b><u>(20,382,637,658.64)</u></b>	<b><u>(4,144,141,687.66)</u></b>
Үүнээс: Цөөнхийн хувь оролцоо		
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>63,577,707,299.79</u></b>	<b><u>64,561,605,788.05</u></b>

5.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан  
Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх тайлант үеийн дүн 2016.12.31	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>54,207,207,920.12</b>	<b>82,883,796,000.82</b>
2	Борлуулалтын өртөг	42,054,657,304.34	41,927,712,796.07
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>12,152,550,615.78</b>	<b>40,956,083,204.75</b>
4	Түрээсийн орлого	323,446,808.06	224,508,552.69
5	Хүүгийн орлого	4,957,305.72	35,122,390.43
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	2,894,340,181.90	4,159,481,679.23
9	Борлуулалт, маркетингийн зардал	7,540,047,030.26	10,583,373,665.21
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,658,964,820.85	3,271,276,417.22
11	Санхүүгийн зардал	2,455,054,047.55	2,355,052,324.80
12	Бусад зардал	8,121,337,861.88	8,648,265,980.98
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз )	(8,185,630,123.16)	850,762,050.64
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз )	138,034,678.41	(3,162,379.19)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз )		
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз )		
17	Бусад ашиг ( алдагдал )		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал )</b>	<b>(14,447,704,293.83)</b>	<b>21,364,827,110.34</b>
19	Орлогын татварын зардал	10,037,420.31	5,651,650,829.26
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(14,457,741,714.14)</b>	<b>15,713,176,281.08</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(14,457,741,714.14)</b>	<b>15,713,176,281.08</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
24	<b>Орлогын нийт дүн</b>	-	-
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал )</b>		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



### 5.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>12,265,209,146.82</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-19,416,893,091.33</b>	<b>-5,924,895,944.50</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								0.00
Залруулсан үлдэгдэл								0.00
Өмчид гаргасан өөрчлөлт								0.00
Зарласан ногдол ашиг								0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-14,457,741,714.14	-14,457,741,714.14
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								0.00
<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>12,265,209,146.82</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-33,874,634,805.47</b>	<b>-20,382,637,658.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								0.00
Залруулсан үлдэгдэл								0.00
Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
Өмчид гаргасан өөрчлөлт							525,319,689.90	525,319,689.90
Зарласан ногдол ашиг								0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							15,713,176,281.08	15,713,176,281.08
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>12,265,209,146.82</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-17,636,138,834.49</b>	<b>-4,144,141,687.66</b>




#### 5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>52,120,435,323.39</b>	<b>90,318,992,984.80</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	50,689,688,425.37	7,731,487,200.29
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,367,298.00	11,237,252.30
1.1.4	Буцаан авсан албан татвар		-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		-
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,422,379,600.02	2,576,268,532.21
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(50,757,323,072.03)</b>	<b>(75,282,333,336.21)</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(16,332,636,225.30)	(16,863,711,365.27)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,211,740,021.32)	(4,284,616,867.94)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(10,400,136,571.64)	(12,708,085,089.54)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(11,228,270,803.51)	(13,629,960,468.69)
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(9,274,536,028.46)	(16,404,342,291.43)
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	(1,327,923,296.92)	(1,172,486,532.41)
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(851,989,819.18)	(9,897,343,367.54)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(42,128,806.00)	(46,785,904.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(87,961,499.70)	(275,001,449.39)
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,363,112,251.36</b>	<b>15,036,659,648.59</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>5,233,275.72</b>	<b>30,895,130.13</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого		-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,233,275.72	30,895,130.13
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(489,876,915.65)</b>	<b>(1,047,439,494.77)</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(489,876,915.65)	(1,047,439,494.77)



2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(484,643,639.93)</b>	<b>(1,016,544,364.64)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>72,042,005.67</b>	<b>185,431,286.06</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.3	Төрөл бүрийн хандив		-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	72,042,005.67	185,431,286.06
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(155,134,988.26)</b>	<b>(12,992,783,736.98)</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(71,078,155.00)	(12,626,707,352.76)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		-
3.2.4	Төлсөн ногдол ашиг		-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(84,056,833.26)	(366,076,384.22)
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(83,092,982.59)</b>	<b>(12,807,352,450.92)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>795,375,628.84</b>	<b>1,212,762,833.03</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>132,489,652.54</b>	<b>927,865,281.38</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>927,865,281.38</b>	<b>2,140,628,114.41</b>





